

РАДИО УДИРДЛАГАТ УРАН НИСЛЭГИЙН ЗАГВАРЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

1. Загварт тавигдах шаардлага

1.1. Хөдөлгүүр. Загвар нь ердийн, эсвэл эргэлтэт поршент дотоод шаталтат хөдөлгүүр, эсвэл цахилгаан хөдөлгүүртэй байх бөгөөд хөдөлгүүр нь ямар ч хэмжээ, ажлын багтаамжтай байж болно. Хөдөлгүүр нь хатуу, хийн, эсвэл шингэрүүлсэн хийн түлштэй байж болохгүй. Цахилгаан хөдөлгүүрийн хэлхээний хүчдэл 42 вольтоос ихгүй байна.

1.2. Дуу чимээний хязгаар. Дотоод шаталтат хөдөлгүүр дуу намсгагчтай байна. Хөдөлгүүрийн дуу чимээ бетонон болон хайрган хучилттай талбайд 96 децибел, шороон болон богино өвстэй талбайд 94 децибелээс ихгүй байна. Загварын хөдөлгүүрийн дуу чимээг загварын их биеийн дагуу тэнхлэгээс 3 метрийн зайнд, уг тэнхлэгийн баруун гар талд, салхины доод талд, газраас 30 см-ийн өндөрт, мотортой нэг шугамд байрлуулсан микрофоноор, моторын эргэлт хамгийн өндөр байх үед хэмжинэ. Загвар болон микрофоны эргэн тойронд 3 хүртэл метрийн зайнд дуу ойлгогч ямар нэгэн зүйл байж болохгүй. Дуу чимээний хэмжилтийг нислэг бүрийн өмнө хийнэ. Хөдөлгүүрийн дуу чимээ 96 децибелээс их байвал нислэгийн суурь оноог 5 хувиар, 96 децибелээс их байвал 10 хувиар бууруулна.

1.3. Жин, хэмжээ. Загварын жин түлшгүйгээр 5 кг-аас ихгүй байна. Цахилгаан хөдөлгүүртэй загварын жинг батарейн хамт тооцно. Загварын далавчны далайц болон загварын урт 2 метрээс ихгүй байна.

1.4. Тоног төхөөрөмж. Загварын радио удирдлага нь загвараас газар руу ямар нэгэн электрон холбоогүй байна. Ямар нэгэн автопилот болон автомат удирдлага, хугацааны механизм хэрэглэхийг хориглоно.

Загварын удирдлагад дараах зүйлүүдийг хориглоно:

- Хурдан (штопортой) торх хийх товчлууур
- Хэд хэдэн командыг автоматаар гүйцэтгэх зорилгоор урьдчилан программчилсан төхөөрөмж
- Загварыг автоматаар тогтворжуулах, шулуун нисгэх зориулалт бүхий гиро гэх мэтийн төхөөрөмж
- Сэнсний алхмыг автоматаар өөрчлөх төхөөрөмж
- Дуу чимээ таних төхөөрөмж
- Загварын нислэг болон дасгалыг санах төхөөрөмж
- Загварын байрлал, зай, өндрийг тодорхойлох GPS зэрэг төхөөрөмж

- Загвараас электрон болон бусад дохио өгөх, эргэх холбоо тогтоох төхөөрөмж
- Загварын байрлал, нислэгийн байдлаас хамааран хөдөлгүүрийн гаралтын чадлыг өөрчлөх аливаа төхөөрөмж

1.5. Тэмцээнд орох загвар. Тамирчин энэхүү дүрмийн шаардлагыг хангасан ямар ч нисэх загвараар тэмцээнд оролцож болно. Гэхдээ нэг загвараар зөвхөн нэг тамирчин тэмцээнд оролцоно.

1.6. Таних тэмдэг. Загвар таних тэмдэгтэй байх ба таних тэмдгийг баруун далавчны дээд талд, эсвэл их биений (эсвэл килийн) хоёр талд байрлуулна. Таних тэмдгийн өндөр 2,54 см-ээс багагүй байна.

2. Туслагч. Тамирчин нислэгийн үед нэг туслагчтай байж болно. Загварыг нислэгийн үед тамирчин зөвхөн өөрөө удирдана. Хөдөлгүүр асаах үед 2 туслагч байж болно. Мөн хоёрдахь туслагч загварыг гараан дээр аваачиж тавьж, загвар газардсаны дараа талбайгаас авч болно. Багийн ахлагч, бусад тамирчин, тусгайлан бүртгүүлсэн этгээд туслагчийн үүрэг гүйцэтгэж болно.

3. Аюулгүй байдал. Тэмцээний үед аюулгүй байдал хамгийн чухал асуудал бөгөөд дараах дүрмийг мөрдлөг болгоно:

3.1.Тэмцээний Ерөнхий шүүгч (ТЭШ) тэмцээнд оролцож буй аливаа загвар, ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгаж, аюулгүй байдлыг хангаагүй байна гэж үзвэл тэмцээнд оролцуулахгүй байх эрх эдэлнэ.

3.2. Нислэгийн талбайг хязгаарлаж, хоёр тийш хязгааргүй үргэлжилсэн шулуун шугамыг нислэгийн шугам гэнэ. Шүүгч нар нислэгийн шугам дээр байрлана. Тэмцээнийг зохион байгуулагчид, тэмцээнд оролцогчид, үзэгчид нислэгийн шугамын ард байрлана. Тамирчин тэмцээний үед загварыг нислэгийн шугамаас гадуур нисгэвэл тухайн дасгалд (дасгалуудын хоорондох шулуун нислэг бол түүний урдах дасгалд) тэг оноо өгнө. Нэг нислэгт 2 удаа нислэгийн шугам зөрчиж тэг оноо авбал хойшхи бүх дасгалд тэг оноо өгч, загвараа буулгахыг тамирчнаас шаардана. Загварыг нислэгийн шугамын ард үргэлжлүүлэн нисгэвэл тухайн тамирчныг тэмцээнээс хасна.

3.3. Нислэг үйлдэж буй тамирчин нисэх, буух талбайн гадна, тусгайлан бэлдсэн нисэгчийн талбайд байна. Загварыг буулгах, эсвэл буусан загварыг авах зорилгоор, шүүгчээс зөвшөөрөл авсны үндсэн дээр нисэх, буух талбайд нэвтэрч болно.

3.4. Бүх загвар хөдөлгүүрийн голыг далдалсан, мохоо үзүүр бүхий коктой байна. Кокны үзүүрийн радиус 3 мм-ээс багагүй байна.

3.5.Далавчны урд ирмэгийн диаметр 2 мм-ээс бага байж болохгүй.

3.6. Тэмцээний үеийн салхины тогтвортой дээд хурд 10,0 м/сек байна. Салхины тогтвортой дээд хурд (салхины гэнэтийн хурд хамаарахгүй) дээрх хязгаараас их байвал ТЕШ тэмцээнийг зогсооно. Мөн салхины хурд нислэгийн талбай болон бусад нөхцөл байдалтай хавсран нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж байна гэж үзвэл ТЕШ нислэгийг зогсоож болно.

3.7. Салхи нислэгийн орон зай, талбайд хөндлөн чиглэлтэй болж, энэ нь нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж байна гэж ТЕШ үзвэл түүний шийдвэрээр нислэгийн орон зай, талбайн чиглэлийг өөрчилж болно.

3.8. Нислэгийн аюулгүй байдал хангагдаагүй гэж үзвэл тамирчин нислэгийг хойшлуулах, эсвэл дахин нислэг үйлдэх хүсэлтээ ТЕШ-д гаргаж болно. Энэ тохиолдолд ТЕШ болон шүүгч нарын нэгдсэн саналаар нислэгийг хойшлуулах, дахин нислэг хийх боломж олгож болно.

4. Тэмцээний ангилал.

4.1. Радио удирдлагат уран нислэгийн загварын тэмцээн нь дунд болон мастер гэсэн хоёр ангилалтай байна.

4.2. Тэмцээнд оролцогч эхний удаа өөрийн сонголтоор дээрх хоёр ангиллын аль нэг ангиллын тэмцээнд оролцоно. Гэхдээ Монгол Улсын спортын мастер, дэд мастерын зэрэгтэй тамирчин зөвхөн мастер ангилалд орно.

4.3. Тамирчин хоёр замаар дээд ангилалд шилжинэ. Үүнд:

а. Тэмцээнд үзүүлсэн амжилтаар. Дунд ангиллын 5 хүртэл оролцогчтой албан ёсны тэмцээнд нэгдүгээр байр эзэлсэн тамирчин, 5-аас дээш оролцогчтой албан ёсны тэмцээнд нэг ба хоёрдугаар байр эзэлсэн тамирчид дараагийн тэмцээнээс эхлэн мастер ангилалд шилжинэ.

б. Сайн дураар. Тамирчин сайн дураараа дээд ангилал буюу мастер ангилалд шилжиж болно. Тэмцээний явцад ангилал солихгүй.

4.4. Нэгэнт мастер ангилалд орсон тамирчин доод ангилал буюу дунд ангилалд шилжихгүй.

5. Нислэгийн тоо. Тэмцээний өмнө ТЕШ тухайн тэмцээнд үйлдэх нислэгийн (давааны) тоог зарлана. Нислэгийн тоог тэмцээнд оролцогчдын тоо, тэмцээний цагийг харгалзан тогтооно. Нислэгийн тоог нэгэнт зарласан бол энэ нь тухайн тэмцээнд заавал нисэх нислэгийн тоо болно. Цаг агаарын тааламжгүй нөхцлийн улмаас нислэгийн цаг алдагдсан бол ТЕШ-ийн шийдвэрээр нислэгийн тоог цөөрүүлж болно. Гэхдээ тэмцээний зохион байгуулагчид тэмцээнд оролцогч бүрийг нислэг хийх адил тэнцүү боломжоор хангах арга хэмжээ авна.

6. Албан ёсны нислэг. Оролдлого хийсэн бол албан ёсны нислэг гэж үзнэ.

6.1. Дараах үйлдлийг оролдлого хийсэн гэж үзнэ:

а. загвар хөөрөх үйлдэл хийхийг тамирчин зарласан бол

б. нислэгт бэлдэх 3 минутын хугацаанд хөөрөх үйлдэл хийж чадаагүй бол.

Тамирчин хөөрөх үйлдэл хийхээ зарласны дараа, гэхдээ загвар газраас тасрахаас өмнө хөдөлгүүр унтарсан бол бэлтгэл 3 минутын дотор хөдөлгүүрийг дахин асааж болно. Гэхдээ хөөрөх дасгалд оноо өгөхгүй.

6.2. Тамирчин албан ёсны нэг нислэгт нэг оролдлого хийх эрхтэй. Гэхдээ гэнэтийн хүчин зүйлээс (өөр загвар агаарт байснаас шалтгаалан аюулгүй байдлыг хангах үүднээс хөөрөхийг хойшлуулах зэрэг) шалтгаалан загвар хөөрч чадаагүй бол зөвхөн шүүгчийн шийдвэрээр оролдлогыг давтаж болно. Мөн ТЕШ тамирчнаас үл хамаарах хүчин зүйлийн улмаас нислэг тасалдсан гэж үзвэл ТЕШ-ийн шийдвэрээр оролдлогыг давтаж болох ба энэ тохиолдолд нислэг тасалдсанаас хойшхи дасгалуудад оноо өгнө. ТЕШ албан ёсны нислэгийн явцад радио долгионы давхцал үүссэн гэж үзвэл оролдлогыг давтах боломж олгох эрхтэй.

6.3. Радио долгионы давхцлын улмаас дахин нислэг хийх загварт ТЕШ-ийн хяналтан дор зөвхөн түлш цэнэглэхийг зөвшөөрөх ба нислэгийг тасалдсан дасгалаас эхлэн үйлдэнэ. Хэрэв радио долгионы давхцал дахин үүсвэл эхний нислэгийн оноог авна.

6.4. Нислэгийн үед загвар мөргөлдсөн тохиолдолд тамирчид загваруудыг нислэгээс яаралтай гаргана. Энэ тохиолдолд оролдлогыг давтаж болох ба нислэгийг тасалдсан дасгалаас эхлэн үйлдэнэ. Нислэгийн цагт түрүү ниссэн цагийг оруулан тооцох ба тамирчин загвараа тохируулахын тулд шүүгч нарын өмнүүр 2 хүртэл удаа шулуун нислэг үйлдэж болно. Тасалдсанаас хойшхи дасгалуудын оноог түрүүний дасгалуудын оноотой нэмж нислэгийн онооны дүнг гаргана. Ийм нислэгийг тухайн давааны сүүлд, эсвэл ТЕШ-ийн тогтоосон бусад цагт үйлдэнэ.

6.5. Тамирчид нислэгийн шугамд дуудахад бэлэн байна. Тамирчныг гарааны талбайд очихоос 5 минутын өмнө дуудна. Даваа дууссаны дараа нөхөн нислэг үйлдэхгүй. Нислэг үйлдээгүй тамирчин тэг оноо авна. Тэмцээнд хожимдсон бол үйлдээгүй нислэг бүрт тэг оноо өгнө.

7. Хугацаа. Тамирчин хөдөлгүүрээ асаах, загвараа хөөргөх үйлдлийг эхлэх 3 минутын хугацаатай байна. Хэрэв тамирчин 3 минутын хугацаанд загвараа хөөргөж чадаагүй бол тэрээр талбайг нэн даруй чөлөөлнө. Загварын дугуй газраас тасарсны

дараа хөдөлгүүр дахин асаахыг зөвшөөрөхгүй. Өгөгдсөн 3 минутын дотор, гэхдээ загвар хөөрөхөөс өмнө хөдөлгүүрийг дахин асааж болно.

8. Онооны систем. Бүх дасгалыг 0-10 хүртэл, бүхэл оноогоор дүгнэж, түвэгшлийн зэрэг (К)-ээр үржүүлнэ. Нислэгийн нийт оноо нь дасгал тус бүрийн К-аар үржүүлсэн онооны нийлбэр байх ба энэхүү нийлбэр оноог суурь оноо гэнэ.

Хэрэв шүүгч тодорхой дасгалыг бүрэн харж амжаагүй бол онооны хуудсанд “ХГ”-хараагүй гэж тэмдэглэнэ. Харж амжаагүй дасгалын оноог бусад шүүгчдийн тухайн дасгалд өгсөн онооны дунджаар авна. Хэрэв бүх шүүгчид тухайн дасгалыг харж амжаагүй бол дахин нислэг хийлгэж, зөвхөн харж амжаагүй дасгалыг үйлдүүлэн оноо өгнө.

9. Ялагчийг тодорхойлох.

9.1. Нислэг бүрийн суурь оноог дараах томъёо ашиглан хувиргаж, нислэгийн тооцооны оноог гаргана. Бүх тамирчид тухайн шүүгчдийн өмнө тус бүр нэг нислэг үйлдсэний дараа хамгийн их оноо авсан тухайн давааны ялагчийн суурь оноог тооцооны 1000 оноо гэж үзнэ. Бусад нислэгийн суурь оноог давааны ялагчийн суурь оноонд хувааж 1000-аар үржүүлэх замаар бусад тамирчдын тооцооны оноог олно.

$$Y = \frac{S_y}{S_w} \times 1000$$

Y = тамирчны тооцооны оноо

S_y = тухайн тамирчны суурь оноо

S_w = тухайн давааны ялагчийн суурь оноо

9.2. Тэмцээнд оролцогч бүх тамирчид тухайн даваанд нислэг үйлдсэний дараа тооцооны оноог гаргаж жагсаана. Тэмцээн нэг даваатай бол нэг нислэгийн тооцооны оноогоор, 2 даваатай бол хамгийн сайн нэг нислэгийн дээд тооцооны оноогоор, 3 даваатай бол хамгийн сайн 2 нислэгийн тооцооны онооны нийлбэрээр, 4 даваатай бол хамгийн сайн 3 нислэгийн тооцооны онооны нийлбэрээр, 5 ба түүнээс дээш даваатай бол хамгийн сайн 4 нислэгийн тооцооны онооны нийлбэрээр тамирчдыг байр эзлүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд тооцоонд ороогүй хамгийн сайн нислэгийн оноог ашиглана.

10. Нислэгийн дасгал, нислэгийн орон зай, талбай.

10.1. Нислэгийн орон зай нь төвийн цэгээс 2 тийш тус бүр 60 градусын шулуун шугамаар, мөн төвөөс дээш 60 градусын шулуун шугамаар хязгаарлагдана. Нислэгийн орон зайг нисэгчийн байрлал(төвийн цэг)-аас хоёр тийш 60 градусын цагаан (гадарга дээр ялгарч харагдах өнгийн) шугамаар тэмдэглэнэ. Нисэгчийн байрлалаас урагш төвийн шугамыг татна. Эдгээр шугамуудыг төвийн цэгээс 50-иас доошгүй метр урттайгаар үргэлжлүүлэн зурсан байна. Нисэгчийн байрлалаас 150 метрийн зайд, төвийн шугамтай перпендекуляр шугам татна. Энэхүү перпендекуляр шугамын төвийн болон захын шугамуудтай огтлолцсон цэгүүдэд тусгай тэмдэг тавина. Тэмдэг нь 100-аас доошгүй мм диаметр, 4-өөс доошгүй метрийн өндөртэй, цагаан өнгийн босоо труба байх ба дээрээ ялгарахуйц өнгийн дарцагтай байна. Нисэгч төвийн болон захын шугамуудын огтолцол дээр байрлах ба шүүгчид нисэгчийн ард, 7-10 метрийн зайд, 60 градусын шугамуудын үргэлжлэлийн доторх талбайд байрлана.

10.2. Хөөрөлт, буултаас бусад дасгалыг нислэгийн орон зайд үйлдэнэ. Төвийн дасгалууд нислэгийн орон зайн төвт, төвийн шугамд хийгдэнэ. Захын дасгалууд хоёр талын 60 градусын шугамуудын дотор хийгдэнэ. Дасгалуудыг шүүгчдээс ойролцоогоор 150-175 метрийн зайнд байрлах шугамд, тэдэнд сайн харагдах орон зайд хийнэ. Загвар нислэгийн орон зайнаас гадагш гарсныг мэдэгдэх дуут болон бусад аливаа дохио хэрэглэж болохгүй. Оноо авдаггүй захын эргэлтүүд нислэгийн орон зайнаас гадна хийгдэж болно. Эхний дасгал хийхээс 15-аас доошгүй метрийн шулуун нислэгийн өмнө нислэгийн хайрцагт орж буйгаа тамирчин зарлан мэдэгдэх ба энэ мөчөөс шүүгчид дасгалуудад оноо өгч эхэлнэ. Сүүлийн дасгалаас хойш 15-аас доошгүй метрийн шулуун нислэг хийсний дараа нислэгийн хайрцагас гарч буйгаа зарлан мэдэгдэх ба энэ мөчөөс эхлэн шүүгчид оноо өгөхийг зогсооно. Мөн нислэгийн 10 минут дуусмагц оноо өгөхийг зогсооно. Шүүгчдийн нислэгт өгсөн оноог даваа бүрийн дараа нийтэд мэдээлнэ.

10.3. Загвар хөөрөх, буухаас бусад тохиолдолд шүүгчдийн өмнүүр нисэж өнгөрөх бүрдээ дасгал хийнэ. Харин загвар хөөрсний дараа болон буухын өмнө шүүгчдийн өмнүүр 2 хүртэл удаа шулуун нислэг хийж болно. Загвар хөөрөх чиглэлийг тамирчин сонгож, шүүгчдэд зарлан мэдэгдэнэ. Дасгалуудын салхи уруудах, салхи өгсөх чиглэл буюу нислэгийн чиглэл нь загвар хөөрөх чиглэлээр тодорхойлогдоно. Эхний дасгал хийх чиглэл нь загвар хөөрсөн чиглэлтэй адил байх ёстой.

10.4. Загварыг салхины уруу буулгахгүйн тулд анх хөөрсөн чиглэлээс өөр чиглэлд суулгах хүсэлтийг тамирчин болон туслах илэрхийлж болох ба энэ тохиолдолд ямар нэг онооны торгууль өгөхгүй. Энэ тохиолдолд загварыг суултанд оруулах зорилгоор шүүгчдийн өмнүүр 2 хүртэл удаа шулуун нислэг хийж болно. Гэхдээ шулуун нислэгийн эргэлтийг талбайн төвд хийж болохгүй.

10.5. Суултаас бусад дасгалыг дарааллын дагуу хийгээгүй бол тэг оноо өгнө. Шүүгчид тухайн дасгал дарааллын дагуу хийгдээгүй тухай тамирчинд болон түүний туслагчид зарлан мэдэгдэж болно.

10.6. Загвар шүүгчдийн өмнүүр зөвшөөрөгдсөнөөс олон удаа шулуун нислэг хийж өнгөрвөл дараагийн дасгалд тэг оноо өгнө.

10.7. Тамирчин дарааллын бус дасгал хийсний дараа, эсвэл зөвшөөрөгдсөнөөс олон удаа шүүгчдийн өмнүүр шулуун нислэг хийснийхээ дараа үлдэх дасгалуудыг дарааллын дагуу, тогтоосон чиглэлээр хийсэн бол тухайн дасгалуудад зохих оноог өгнө.

10.8. Загварыг агаарт гарсны дараа тамирчин, түүний туслагч загварт гар хүрэхийг хориглоно. Өөрөөр хэлбэл загвар агаарт гарсны дараа хөдөлгүүр болон залууруудад тохиргоо хийх зэрэг зорилгоор загварыг газарт буулгахыг хориглоно.

10.9. Тамирчин, эсвэл түүний туслагч загвар хөөрөх, буух, нислэгийн хайрцагт орох, нислэгийн хайрцагаас гарах тухай бүр зарлан мэдэгдэнэ.

10.10. Загвар хөөрөх, буух үед шүүгчдийн өмнүүр үйлдэж болох зөвшөөрөгдсөн шулуун нислэгийн үед элдэв чөлөөт маневр хийхийг хориглоно. Загварын залуурыг тохируулахын тулд маневр хийхдээ 180 градусын эргэлтүүдийг ашиглаж болно. Зөвшөөрөгдсөн шулуун нислэгийн үед хориглосон маневр хийсэн гэж шүүгчид үзвэл дараагийн дасгалд тэг оноо өгнө.

10.11. Загварыг гараас шидэж хөөргөх, гарт буулгахыг хориглоно.

10.12. Нислэгийн үед загварын аль нэг хэсэг салж унавал үүнээс хойших дасгалд оноо өгөхгүй ба загварыг яаралтай буулгана.

10.13. Иж бүрэн дасгалын суултын өмнөх дасгал загвар анх хөөрсөн чиглэлд дуусах ёстой.

11. Нислэгийн иж бүрэн дасгал.

Нислэгийн иж бүрэн дасгал нь дунд, мастер гэсэн хоёр ангилалд хуваагдана. Дунд шатны иж бүрэн дасгалд АНУ-ын Нисэх загварын академи (АМА)-ийн дунд шатны (intermediate) түвшний тухайн оны иж бүрэн дасгалыг, мастерын иж бүрэн дасгалд мөн академийн мастерын (masters) түвшний тухайн оны иж бүрэн дасгалыг тус тус авч тэмцээн уралдааныг зохион байгуулна.

12. Тэмцээний талбайд хийгдэх ажилбарууд. ТЕШ дараах ажлуудыг зохион байгуулах ба тухайн талбайн нөхцөл байдлаас хамааруулан өөрчлөлт оруулж болно.

12.1. Тэмцээнд оролцож буй тамирчид ТЕШ-ийн заасан талбайд, түүний шууд хяналтанд байрлана.

12.2. Нислэгийн үед радио удирдлагын нэвтрүүлэгч болон хүлээн авагчийн туршилт, тохируулга хийхийг хориглоно. Нэвтрүүлэгчийн радио долгионы давхцлаас сэргийлэх зорилгоор тусгай самбар ажиллуулах ба бүх тамирчид өөрийн ашиглаж буй долгионы давтамжийг самбарт тавьж бүртгүүлсэн байна. Нислэг хийгээгүй тамирчид тэмцээний нислэгийн үед загварын хөдөлгүүр асаахыг хориглоно. Тэмцээний нислэгийн үед радио долгионы давхцал үүсгэсэн, хөдөлгүүр асаасан тамирчныг тэмцээнээс хасна. ТЕШ долгионы давхцал шалгах багажтай байх хэрэгтэй.

12.3. Тамирчдын нислэг үйлдэх дарааллыг сугалаагаар тогтооно.

12.4. Нислэгийг наад зах нь **2 шүүгч шүүх ба тэдний өгсөн онооны дунджаар нислэгийн суурь оноог гаргана.** Дасгалыг хийсэн даруйд оноог нь өгнө. Шүүгчид зөвхөн өөрийн оноог өгөх ба оноо өгөхдөө хоорондоо зөвлөлдөж болохгүй. Шүүгчдийн тухайн баг тэмцээнд оролцсон бүх тамирчдын, тэнцүү тооны нислэгийг шүүнэ. Хэрэв тэмцээний явцад шүүгчид солигдвол, шинээр бүрдсэн шүүгчдийн баг тэмцээнд оролцогч бүх тамирчдын, тэнцүү тооны нислэгийг шүүх ёстой. Цаг уурын тааламжгүй нөхцөл бий болсон зэрэг шалтгаанаар тэмцээнд оролцож буй бүх тамирчид тухайн шүүгчдийн багийн өмнө тэнцүү тооны нислэг үйлдэж чадаагүй бол тухайн нислэгүүдийн дүнг ТЕШ-ийн шийдвэрээр хүчингүйд тооцно.

12.5. ТЕШ тэмцээний нислэгт нарны гэрэл саад болохгүй байх адил тэнцүү нөхцлөөр тамирчдыг хангах үүрэгтэй. Ингэхийн тулд нислэгийн орон зайн чиглэлийг өөрчлөх, тэмцээний цагийн хуваарийг өөрчлөх зэрэг арга хэмжээ авна.